



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/619

Номгон

Г “Угийн бичиг хөтлөх” арга хэмжээг Г
эрчимжүүлэх тухай

Монгол үндэстний түүх, өв соёлоо эрхэмлэн дээдлэх, үндэс угсаа, удмаа мэдэх, хойч үедээ өвлүүлэх, “Угийн бичиг” хөтлөх арга, аргачлалыг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 /а/, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/8 дугаар тогтоолоор баталсан аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 2.2.22 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварын гарын авлагыг хавсралтаар баталсугай.

2. Гарын авлагыг өрхүүдэд түгээж төрийн болон ТББ-ын оролцоог ханган угийн бичиг хөтөлдөг айл өрхийг нэмэгдүүлэх арга хэмжээг чанартай зохион байгуулахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр), Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар (Н.Мэндбаяр)- т тус тус үүрэг болгосугай.

3. Гарын авлага хэвлэхэд шаардагдах 5,000,000 (Таван сая) төгрөгийг аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа) -т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210445